




ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2019 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2020/131/СТА-ТШ3

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер Г.Гунжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор Ж.Болормаа
Утас: 261628 Цахим хаяг: bolormaaj@audit.gov.mn



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Б.НАРАНТУЯА ТАНАА

2022. Ок. 21 06, 58'

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зерчилгүй санал дүгнэлт

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцуулж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хетплэлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглувансан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохицой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дунд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланда тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланда санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

З. М.

Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

Оршил

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлантгийн аудитын дүн, дүгнэлтийг ерөнхий захирал Б.Нарантуяа Танд танилцуулж байна.

Энэхүү тайландаа үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, запруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зерчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, холбогдох хууль, журам, зааврыг хэрэгжүүлж ажиллах, анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгахгүй байх, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлзээ.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.


Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 08-наас 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа, гэрээт аудитор Н.Нямсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 85 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хулээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагасан санхүүгийн тайландаа аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалын баталгаажуулсан болно.



Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоо бурдүүлэх, байгууллага, хүний нөөц, техник технологи, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, салбарын удирдлага, манлайллыг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх"-д оршино" гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.
Үүнд:

- Эрүүл мэндийн салбарын бодлогын болон тогтолцооны судалгааг хөгжүүлэх;
- Статистик мэдээ, мэдээлэл, зайн анагаах ухаан, цахим эрүүл мэнд, мэдээллийн технологийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах;
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хууль эрхзүй, шалгалт баталгаажуулалт, засвар үйлчилгээ, сургалт, бүртгэл мэдээллийн тогтолцоог бэхжүүлэх;
- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг боловсронгуй болгох;
- Тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжлийг дэмжин, чанар, аюулгүй байдал, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлэх;
- Эмийн зохицуулалтын үйл ажиллагааг олон улсын эмийн зах зээлийн хөгжлийн түвшинд нийцүүлэх;
- Байгууллагын бие даасан, тогтвортой байдлыг хангах зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэн ажилладаг байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Нягтлан бodoх бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайландаа материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бodoх бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь ЭМЯ-наас 2010 онд боловсруулсан Эрүүл мэндийн салбарын нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх байна. Тус Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын онцлогт тохиоогүй, Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжийн холбогдох өөрчлөлтүүдийг бүрэн тусгаагүй байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаандадаа Гүүк софт ХХК-ийн Динамик программ хангамж ашигладаг байна.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрүүл мэндийн хөгжлийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 19 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

**Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,502,045.5 мянган төгрөгөөс тооцон 110,040.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь, хувь хэмжээг өөрчлөөгүй 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,748,415.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцож материаллаг байдлын түвшинг 114,968.3 мянган төгрөгөөр тогтоолоо.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтгүүд

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68,608.2 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар өссөн байна. Үүнд:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/


Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	11,664.8	-	(11,664.8)
Бараа материал	135,971.9	151,014.8	15,042.9
Үндсэн хөрөнгө	1,984,894.4	2,050,124.5	65,230.1
Нийт хөрөнгийн дүн	2,132,631.1	2,201,139.2	68,608.2
Нийт өр төлбөр	230.0	0.0	(230.0)
Засгийн газрын оруулсан капитал	2,132,301.1	2,201,139.2	68,838.2
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,132,631.1	2,201,139.2	68,608.2

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд нэмэлт санхүүжилтийн харилцах данснаас Сангийн яаманд төвлөрүүлсэн 11,664.8 мянган төгрөгийг буцаан авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 15,042.9 мянган төгрөг буюу 11.1 хувиар өссөн нь бусад хангамжийн материал 10,165.0 мянган, хэвлэмэл материал 4,183.6 мянган, бичиг хэргийн материал 2,990.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нийт дүнгээр 65,230.1 мянган төгрөг буюу 3.3 хувиар өссөн байна. Тухайлбал:

- ЭМЯ-наас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 31,500.0 мянган төгрөгийн өртөгтэй УАЗ-22069 маркийн фургон автомашин;
- “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт, баталгаажуулалтын болон засвар үйлчилгээний тоног төхөөрөмж, багаж нийлүүлэх” тендерээр бэлтгэсэн 82,486.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, компьютер, техник хэрэгсэл;
- Дэлхийн банкны хөнгөлөлтэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Цахим эрүүл мэнд” төслийн хөрөнгөөр бэлтгэсэн 123,619.3 мянган төгрөгийн өртөгтэй сургалтын төвийн компьютер, тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тавилга, ургал төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 68,296.1 мянган төгрөгийн хөрөнгө ТӨБЗГ-аас зөвшөөрөл авч бэлтгэсэн зэрэг нийт 313,401.7 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн.
- Ашиглах хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртөө нэхсен 154,449.3 мянган төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын тогтоолын дагуу акталж данс бүртгэлээс хассан дүнгээр буурсан байна.



**Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Өмнөх онд данс андуурсан гүйлгээний 230.0 мянган төгрөгийн өглөгийг буцааж төлжээ.

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 2,201,139.2 мянган төгрөг болж тайлант үеийн үр дүн 68,838.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга, хэвийн бус өөрчлөлт, онцгой шинжтэй ажил гүйлгээ гаралаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шуд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрүүл мэндийн хөгжлийн төв тайлант онд 5,380,996.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас, улсын төсвээс 4,715,996.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 725,735.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, нийт 5,441,732.5 мянган төгрөгийг бүрдүүлжээ. Үүнээс ургал зардалд 5,370,441.4 мянган, давсан орлогоос 30,906.2 мянган төгрөгийг нэмэлт төсвийн санхүүжилтийн дансанд шилжүүлэн зарцуулж, 40,384.9 мянган төгрөгийг Сангийн яаманд төвлөрүүлсэн байна. Тухайлбал:

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн тайлант онд 665,000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 725,735.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.1 хувиар биелүүлсэн байна.

Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны орлого нийт дүнгээр 53,308.2 мянган төгрөгөөр давсан нь эм ханган нийлүүлэх байгууллагуудаас бүртгүүлж байгаа эмийн нэр төрөл, тоо нэмэгдэж байгаагаас шалтгаалж эмийн бүртгэлийн хураамж 58,630.5 мянган, тухайн жилд улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэлийн хугацаа сунгах, шинээр олгох тоо хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалж төлбөр 12,455.1 мянган төгрөгөөр давж биелсэн. Эмнэлгийн мэргэжилтний эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын хураамжийн орлого шалгалтад хамрагдаж байгаа мэргэжилтнүүдийн тооноос шалтгаалж 5,552.4 мянган, эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын төлбөр тохируулга баталгаажуулалт хийх хугацаанаас шалтгаалж 12,455.1 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.
- Туслах үйл ажиллагааны орлого суралцагчдын сургалтын тэтгэмжээс байрны төлбөрийг суутган тооцдог болсноор авлага үүсэлгүй орлого бүрэн төвлөрч 7,427.6 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх эрүүл мэндийн бодлого, удирдлагын хөтөлбөрт зориулан 5,380,996.7 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Ургал зардалд 5,370,441.4 мянган төгрөгийг зарцуулж 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Тухайлбал: Байр ашиглалттай холбоотой зардлыг 1,832.7 мянган, хангамж, бараа материалын зардал 2,323.5 мянган, эд хогшил, ургал засварын зардал 1,337.8 мянган, дотоод албан томилолтын зардлыг 1,427.8 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1,780.8 мянган, бараа үйлчилгээний бусад зардлыг 685.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 118.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Нэмэлт төсөв: Эрүүл мэндийн хөгжлийн төвийн нэмэлт төсвийн дансанд 162,791.5 мянган төгрөгийн орлого төвлөрчээ. Үүнд:

**Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны санхүүтийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсон санхүүтийн тайланийн аудит**

- ДЭМБ-аас зохион байгуулсан төвлөрсөн арга хэмжээ, сургалт, судалгааны ажил, шалгалтын сорилын сангийн баяжилт хийх, сорил шинээр боловсруулах, эмхэтгэл орчуулах, цахим хуудас хөгжүүлэх зэрэг ажилд зориулж нийт 73,550.5 мянган төгрөгийн санхүүжилт;
- Эрүүл мэндийг дэмжих сангаас "Сувилагч мэргэжил сайхан" нөлөөллийн арга хэмжээний хөтөлбөрт 12,500.0 мянган, Эрүүл амьдралын төлөө-2019 хөтөлбөрт санхүүжилтэд 34,400.0 мянган төгрөг, нийт 46,900.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.
- Үндсэн болон туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон 60,735.8 мянган төгрөгийн давсан орлогоос 30,906.2 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн;
- НҮБ-ийн хүн амын сангаас олгосон төслийн санхүүжилт 11,434.8 мянган төгрөгийг өмнөх онд Сангийн яаманд төвлөрүүлснийг буцаан олгосон;

Дээрх орлогыг хөтөлбөр арга хэмжээний зориулалтын дагуу зарцуулж үлдэгдэл 3,794.0 мянган төгрөгийг ДЭМБ-д буцааж шилжүүлсэн байна.

Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 19 эрсдэлтэй асуудлыг тодорхойлж горим, сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,740,362.2 мянган төгрөгийн алдаа, зерчил илэрснээс, 2,684,300.0 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланц залруулга хийлгэж, 12,590.9 мянган төгрөгийн 2 зерчилд албан шаардлага хүргүүлж, 43,471.3 мянган төгрөгийн алдаа зерчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө. Үнд:

1. Эрүүл мэндийн сайдын 2018 оны "Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" А/21 тушаалын 1 дугээр хавсралтын 7.6-д Захиргаа, санхүү, дотоод хяналтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний чиг үүрэгт хамааралгүй "Зураглаач" гэсэн орон тоон дээр 1 ажилтан ажиллуулж 12,590.9 мянган төгрөгийн цалин олгосон байна. Тус ажилтны цагийн бүртгэл нь ЭМЯ-нд бүртгэгддэг байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.


2. Цагийн бүртгэлийг хянаж баталгаажуулаагүй, цалин хөлсийг тооцохдоо өмнөх сарын ажлын цагийн мэдээлэлд үндэслэн, сар бүр 22 хоногоор тооцож олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2."Цагаар ажиллах" гэж ажил олгогчоос тодорхой ажил, үүргийг биечлэн гүйцэтгүүлж, гүйцэтгэсэн ажлын хэмжээ, ажилласан цагт нь тохирсон цалин хөлсийг тухай бүр тооцож олгохыг хэлнэ." гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Санхүүгийн байдлын тайлангийн Засгийн газрын хувь оролцоо дансны өмчийн хэлбэрийг хувийн өмчийн зээмшилийн хувь 3,276,900.0 мянган, төрийн өмчийн зээмшилийн хувийг хасах тэмдэгтэйгээр 886,400.0 мянган төгрөгөөр, нийт 2,390,500.0 мянган төгрөгөөр алдаатай бүртгэж ирсэн. Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,584,200.0 мянган, эхний үлдэгдэл 2,290,400.0 мянган төгрөг буюу 293,800.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэгдсэн.

Дээрх асуудлууд нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "унэн зөв байх;" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдааг санхүүтийн тайланц залруулсан.



**Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны санхуугийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхуугийн тайлангийн аудит**

**Аудитаар иларсан 43,839.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн
захидалд тусгалаа.**

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

**Ажлаас чөлөөлөгдсөн 5 ажилтанд Шүүхийн шийдвэрийн дагуу олгох ажилгүй байсан
хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтэл 50,730.4 мянган төгрөгийн нэхэн олговрыг
өгсөн зөрчилд буруутай албан тушаалтнаар төлүүлэх албан шаардлагыг холбогдох дээд
шатны төсвийн захирагчийн дотоод аудитын нэгжид хүргүүлэхээр шийдвэрлэв.**

Шилэн дансны мэдээлэл

**Төсвийн захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг
өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.**

**Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан батлагдсан төсөв, гүйцэтгэл,
хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс
дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө
зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэрэг мэдээллүүдийг хугацаанд, 1
мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.**

Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

**Өмнөх оны санхуугийн тайлангийн аудитаар өгсөн 15,000.0 мянган төгрөгийн зөрчилд
1 төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан, хууль, тогтоомж, журам, заавар мөрдөж
ажиллаагүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан, кассын журнал хөтлөөгүй зэрэг 21,987.5
мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.**

**Орлогыг ангилж бүртгээгүй, дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, ТӨБЗГ-ын
шийдвэргүйгээр хөрөнгө балтгэсэн зэрэг алдаа, зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгснийг
хэрэгжүүлж ажилласан байна.**

Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

**Бид Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны санхуугийн тайлан, төсвийн
гүйцэтгэлийн тайландауд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын
холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.**

**Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхуугийн байдал,
санхуугийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчилэл тодрууллыг
холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой
илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.**

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидалын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сүл талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринеас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас 5,833.5 мянган төгрөгийг ахмадын санд шилжүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” гэж заасныг зөрчиж байна.

3.1.2. Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх, хөрөнгө үрэгдэх, хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байх;

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх, журам, зааврыг мөрдөж ажиллах;

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тус төвийн 2 дугаар байрны харул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй хувь хүмүүстэй шууд гэрээ байгуулан ажиллуулж 33,000.0 мянган төгрөг олгосон байна.

3.2.2 Эрсдэл:

Бараа ажил, үйлчилгээний балтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгчийг хууль, журам зааврын дагуу сонгон шалгаруулаагүй байх;

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн сонгон шалгаруулалт явуулж байх;

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

Балансын данстай холбоотой асуудал

3.3.1. Илрүүлэлт:

Худалдан авсан, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт анхан шатны бурдэл дутуу баримтаар 3,900.0 мянган төгрөг, магадлан итгэмжлэлийн орон тооны бус 1 шинжээчтэй гэрээ байгуулаагүй, 5 шинжээч гэрээнд гарын үсэг зурж баталгаажаагүй баримтаар 510.3 мянган төгрөг, эмийн зөвлөлийн 4 гишүүний оролцсон хурлын ирцийг бүртгээгүй урамшуулалт 227.5 мянган төгрөг, нийт 4,637.8 мянган төгрөгийг олгосон байна.

Дээрх асуудлууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланда тусгахыг хориално." гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, баримт материалыг зохих журмын дагуу бурдүүлээгүй байх, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх;

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгахгүй байх;

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

Балансын данстай холбоотой асуудал

3.4.1. Илрүүлэлт:

Төвийн санхүүгийн тайланд 121,333.0 мянган төгрөгийн өртөгтэй 4 автомашин бүртгэлтэйгээс 2008, 2009 онд ашиглалтад орсон 49,883.1 мянган төгрөгийн өртөгтэй 2 автомашин ашиглалтгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчийн хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдал үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашигтүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж акт тогтоон устгаж болно." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй ажиллаагүй байна.

3.4.2. Эрсдэл:

Эд хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, хадгалалт хамгаалалт хангалтгуйгээс чанар байдал алдагдсан байх;

3.4.3. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, эрх бүхий байгууллагад хандаж хэрэгцээ шаардлагатай
газарт нь шилжүүлэх арга хэмжээ авах;

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

Тайлант хугацаанд хэрэгжүүлэх өрөнхий чиглэлтэй холбостой асуудал

3.5.1. Илрүүлэлт:

Эрүүл мэндийн хөгжлийн төв нь ЭМЯ-наас 2010 онд боловсруулсан Эрүүл мэндийн
салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Тус Нягтлан
бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын үйл ажиллагааны онцлогт
нийцээгүй, Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого,
холбогдох стандарт, хууль тогтоомжийн холбогдох өөрчлөлтүүдийг бүрэн тусгаагүй байна.

3.5.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллаагүй байх;

3.5.3. Өгсөн зөвлөмж:

УСНББОУС, холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн байгууллагын үйл ажиллагааны
онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж
мөрдөж ажиллах;

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар
сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал
илэрхийлье.

**Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	147,636,669.00	151,014,761.00
33	АВЛАГА	11,664,770.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	11,664,770.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	135,971,899.00	151,014,761.00
351	Түүхий эд материал	32,513,500.00	30,350,310.00
35110	Тусгай зориулалттай материал	1,925,000.00	6,108,600.00
35130	Эм боох материал	30,588,500.00	24,241,710.00
354	Хангамжийн материал	103,458,399.00	120,664,451.00
35410	Бичиг хэргийн материал	2,936,276.00	5,926,272.00
35420	Аж ахуйн материал	1,038,245.00	3,692,640.00
35430	Сэлбэг хэрэгсэл	9,013,454.00	11,403,954.00
35440	Түлш, шатах тослох материал	16,450,160.00	12,081,105.00
35450	Барилгын засварын материал	2,968,584.00	6,343,784.00
35470	Бусад хангамжийн материал	71,051,680.00	81,216,696.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,984,894,402.13	2,050,124,480.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,984,894,402.13	2,050,124,480.87
392	Биет хөрөнгө	1,849,873,296.18	1,923,421,445.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,479,086,220.71	1,479,086,220.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	(482,964.14)	(101,614,890.38)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,833,120.00	121,333,120.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(61,868,120.12)	(65,863,120.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,253,670,958.89	1,380,346,790.89
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,043,978,229.85)	(1,040,094,081.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хөгшил	316,661,563.00	325,796,120.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(190,545,308.31)	(189,944,189.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,409,713.00	24,909,713.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(14,681,813.00)	(15,302,393.00)
39217	Ном	4,768,156.00	4,768,156.00
